

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 03 өдөр

№ 108/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Улсын бүртгэлтийн РД:5117194 дугаартай “Хорин дөрвөн цаг” ХХК / цаашид түрээслүүлэгч гэх/-ийг төлөөлж захирал Д.Халиунаа, нөгөө талаас Улсын бүртгэлийн РД:6021646 дугаартай “Амгалан дулааны станц” ТӨХК / цаашид түрээслэгч гэх/-ийг төлөөлж Аж ахуй хангамжийн хэлтсийн дарга Г.Эрдэнэбилэг нар Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.2.Түрээслүүлэгч нь нэг автомашины дулаан зогсоолыг түрээслэгчид ашиглуулах, түрээслэгч нь энэхүү гэрээнд дурьдсан нөхцлөөр дулаан зогсоолыг ашиглах, төлбөрийг төлөх харилцааг зохицуулна.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1.Энэхүү гэрээг талууд харилцан тохиролцож гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд дулаан зогсоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл /6 сар/ хугацаатай ашиглахаар байгуулав.

-Түрээслэгчийн машины дугаар 80-19 УБК Шуурхай ажиллагааны Starex маркийн тээврийн хэрэгсэл

-Түрээслүүлэгчийн тээврийн хэрэгслийн байрлах талбайн дугаар: Зогсоол №61

Гурав. Гэрээний төлбөр тооцоо

3.1. Нэг хоногийн түрээсийн төлбөр 11,000 /арван нэгэн мянга /төгрөг байна.

3.2.Түрээслүүлэгчийн 6 сарын гэрээний төлбөр 2,013,000 / хоёр сая арван гурван мянга/-н төгрөг, дээрх төлбөрт НӨАТ орсон болно.

3.3.Түрээслэгч түрээсийн төлбөрийг Хаан банкин дахь 5069001033 тоот дансанд шилжүүлж төлбөрийн баримтыг өгөх буюу бэлнээр кассанд тушааж төлбөрийн баримт авна.

3.4.Гэрээг дуусгавар болтол гэрээ болон төлбөрийг баримтыг үрэгдүүлэхгүй байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг, хариуцлага

4.1.Түрээслүүлэгч нь цэвэр цэмцгэр, дулаан орчныг бүрдүүлж техникийн аюулгүй байдлыг бүрэн хангаж өгнө.

4.2.Байгалийн болон гэнэтийни давагдашгүй хүчин зүйлийн гэх мэт түрээслүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар тээврийн хэрэгсэлд хохирол гарвал түрээслүүлэгч нь төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

4.3. Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг цуцалбал тавиагүй хоногийн төлбөрийг дүнгийн 15 хувийг суутган тооцно.



4.4.Түрээслэгч тээврийн хэрэгслийн байрлах талбайд машинаа тавиагүй үеийн хоногийг нөхөн тавиулахгүй.Түрээслэгч тээврийн хэрэгслийн байрлалд өөр хэрэгсэл тавиулах бол урьдчилан мэдэгдэж тухайн тээврийн хэрэгслийн дугаарыг харуул хамгаалтын ажилтанд тэмдэглэл хийлгэсэн байна.

4.5.Түрээслэгч харуул хамгаалалтын ажилтанд машины түлхүүрийг үлдээхгүй байх, машины түлхүүрийг үлдээснээс үүдэн гарах аливаа асуудлыг “Хорин дөрвөн цаг” ХХК хариуцахгүй.

4.6.Тээврийн хэрэгсэлийн жолооч зогсоолд машин тавихдаа бусдын өмчид хохирол учруулсан бол 100% хариуцан төлбөрийг барагдуулж хохиролгүй болгоно.

4.7.Зогсоолд машинаа угаах, засвар үйлчилгээ хийхийг хориглоно.Зайлшгүй хийх шаардлага гарвал урьдчилж зөвшөөрөл аван, кассанд төлбөрөө тушаасны дараа хийнэ.

4.8. Түрээслэгч нь гэрээний төлбөрөө төлөөгүй бол гэрээг цуцлах, машины улсын дугаарыг хурааж авах арга хэмжээ авах ба төлбөрөө төлсний дараа зогсоолоос гаргана.

4.9.Түрээслэгч нь машинаа тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан байх шаардлагатай.

Тав. Бусад

5.1. Гэрээний талаар талуудын хооронд үл ойлгоцол үүсвэл харилцан бие биеэ хүндэтгэн эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд эс чадвал хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол талууд харилцан тохиролцож эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болно.

Зургаа.Нэмэлт нөхцөл

Гэрээ байгуулсан талуудын төлөөлөл:

“АМГАЛАН ДУЛАНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.МӨНХӨӨ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

Ө.УДВАЛ

АЖ АХУЙ ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Г.ЭРДЭНЭБИЛЭГ

ХУУЛИЙН МӨРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

“ХОРИН ДӨРВӨН ЦАГ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ХАЛИУНАА

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

АХММХ-ИЙН АВТО ИНЖЕНЕР

 Н.САЙНБИЛЭГ

Талуудын албан ёсны хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
8 дугаар хороо УС15-1-1
Утас:77111252, факс:77111253

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг
14 дүгээр хороо, 51 дүгээр байр
Утас:70150145, 91915665

У
Д
А
Л
Д
А
А